



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/30

Номгон

Газар эзэмших эрхийн гэрчилгээт
дуудлага худалдааны ялагч Э.Мөнхдалайд
газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 120 дугаар тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн "Аймгийн газар зохион байгуулалтын 2025 төлөвлөгөө батлах тухай" 3/18 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн газар зохион байгуулалтын 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан Баянхонгор сум Рашаант 10-р багт байрлах "Үйлчилгээтэй орон сууц"-ны зориулалттай 643м2 газрын газар эзэмших эрхийн гэрчилгээт дуудлага худалдаанд оролцож ялагч болсон Угалз 4 дүгээр багийн иргэн Э.Мөнхдалай РД:ВЮ87051516 түр нэгж талбар 4328745-ын дугаар бүхий "Үйлчилгээтэй орон сууц"-ний зориулалттай 643м2 газрыг 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2.Эзэмшил газрыг цахим системд бүртгэн цахим гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т, эзэмшил газарт Улсын бүртгэлийн "Э" дугаар олгохыг Улсын бүртгэлийн хэлтэс (Ц.Мөнхжаргал)-д, эзэмшил газраа зориулалтын дагуу зүй зохистой эзэмшиж гэрээнд заасан үүргээ биелүүлж жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмшигч иргэнд тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Энхбаяр)-т даалгасугай.

ДАРГА

Э.ЭНХБАТ



626010071

